

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/139/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichnkhorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГҮҮЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. Аудитын тайлан	14
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын тапаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
Төлбөрийн акт тогтоогоогүй болно	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар



ЦАГААН-ҮҮР СУМЫН ЗАСАГ ДАРГА
А.БАТМӨНХ ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.24 № 01/284
танай _____ -ны № _____ -т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудаас ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэнээр 1,770.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 543.4 сая төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 953.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч нэр төрлөөр нь авч үзвэл 28.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Цагаан-Үүр сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 87 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,465,180.9	1,822,780.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	423,041.2	1,237,896.8
33	АВЛАГА	209,934.4	77,653.0
35	БАРАА МАТЕРИАЛ	774,326.3	404,671.6
36	НӨӨЦИЙН БАРАА	57,879.0	102,559.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,546,311.8	870,799.0
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	87,000.0
37300	Урт хугацаат зээл	0.0	87,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,546,311.8	783,799.0
39200	Биет хөрөнгө	2,385,097.1	687,717.2
39300	Биет бус хөрөнгө	161,214.8	96,081.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,011,492.7	2,693,579.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,118.8	5,123.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,118.8	5,123.5
41300	Өглөг	8,118.8	5,123.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,003,373.9	2,688,456.4
51	Засгийн газрын хувь оролцоо	4,003,373.9	2,688,456.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	7,291,881.5	5,320,570.3
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	7,291,881.5	5,320,570.3
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	2,221.9	2,221.9
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	33,281.0	33,281.0
51200	Хуримтлагдсан үр дүн	-3,620,712.5	-2,721,046.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	496,702.1	53,431.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,011,492.7	2,693,579.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,566,362.5	2,258,779.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	240,738.2	1,259,808.3
110	Орлогын албан татвар	25,868.1	169,469.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	25,868.1	184,917.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-15,448.1
113	Хөрөнгийн албан татвар	7,146.2	13,935.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	207,724.0	1,076,402.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	527,228.2	243,719.7
120	Нийтлэг татварын бус орлого	525,978.2	243,719.7
121	Хөрөнгийн орлого	1,250.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,798,396.0	755,251.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,070,449.8	1,063,879.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,070,449.8	1,063,879.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,996,394.4	997,750.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,777,528.6	363,475.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	233,725.2	46,242.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	141,703.1	186,352.1
2104	Хангамж, бараа материалын зардал	100,914.2	46,944.3
2105	Нормативт зардал	336,235.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,007.5	35,238.6
2107	Томилолт, зочны зардал	6,895.7	6,180.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	131,527.2	156,975.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	238,858.1	156,342.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,055.4	66,129.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	495,912.7	1,194,899.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	100,691.3	2,404,589.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	395,221.4	-1,209,689.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,048,991.6	2,159,486.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	240,738.2	1,259,808.3
110	Орлогын албан татвар	25,868.1	169,469.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	25,868.1	184,917.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-15,448.1
113	Хөрөнгийн албан татвар	7,146.2	13,935.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	207,724.0	1,076,402.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,819.7	58,378.5
1181	Газрын төлбөр	10,564.3	7,749.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	186,339.9	1,010,274.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	166,466.2	144,426.5
120	Нийтлэг татварын бус орлого	165,216.2	144,426.5
121	Хөрөнгийн орлого	1,250.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,641,787.2	755,251.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,687,444.6	1,081,995.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,687,444.6	1,081,995.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,699,347.8	894,338.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,816,495.3	410,063.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	243,342.5	52,065.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,840.7	176,865.7
2104	Хангамж, бараа материалын зардал	124,988.8	57,276.7
2105	Нормативт зардал	169,921.9	2,995.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,594.2	35,238.6
2107	Томилолт, зочны зардал	6,895.7	6,180.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,485.9	96,413.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,782.8	57,240.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	988,096.9	187,657.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	361,547.0	1,077,490.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	387,415.4	181,882.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	387,415.4	181,882.9
2200	Дотоод эх үүсвэрээр	387,415.4	181,882.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-387,415.4	-181,882.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-80,752.1
14	Бусад эх үүсвэр	0.0	35,247.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	116,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-25,868.4	814,855.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	448,909.7	423,041.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	423,041.2	1,237,896.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,606,556.6	3,606,556.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	212,143.1	212,143.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,818,701.7	3,818,701.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-210,623.6	-210,623.6
9	Тайлант үеийн үр дүн	395,295.9	395,295.9
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,003,373.9	4,003,373.9
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,003,373.9	4,003,373.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-105,227.9	-105,227.9

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,898,146.0	3,898,146.0
19	Тайлант үеийн үр дүн	-1,209,689.6	-1,209,689.6
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,688,456.4	2,688,456.4

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,484,257.7	1,269,468.5	214,789.2	85.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,093,014.9	985,815.5	107,199.4	90.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	816,345.2	775,175.8	41,169.4	95.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	387,493.2	363,476.2	24,017.0	93.8
210101	Үндсэн цалин	386,528.4	307,104.4	79,424.0	79.5
210102	Нэмэгдэл	-	42,909.2	(42,909.2)	
210104	Урамшуулал	964.8	13,462.6	(12,497.8)	1,395.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,642.8	46,241.8	2,401.0	95.1
210201	Тэтгэврийн даатгал	33,277.7	31,540.2	1,737.5	94.8
210202	Тэтгэмжийн даатгал	3,841.8	3,710.7	131.1	96.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,073.5	2,931.6	141.9	95.4
210204	Ажилгүйдлийн даатгал	766.0	730.6	35.4	95.4
210205	Эрүүл мэндийн даатгал	7,683.8	7,328.7	355.1	95.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	176,867.0	176,865.7	1.3	100.0
210301	Гэрэл, цахилгаан	40,797.4	39,615.2	1,182.2	97.1
210302	Түлш, халаалт	131,509.6	132,690.5	(1,180.9)	100.9
210303	Цэвэр, бохир ус	4,560.0	4,560.0	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	36,091.5	34,588.7	1,502.8	95.8
210401	Бичиг хэрэг	7,960.0	7,960.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	16,165.6	16,165.6	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,920.0	3,613.2	1,306.8	73.4
210404	Ном, хэвлэл	1,060.0	864.0	196.0	81.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,301.9	3,301.9	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,684.0	2,684.0	-	100.0
2105	Нормативт зардал	2,995.0	2,995.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,995.0	2,995.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,238.6	39,238.6	4,000.0	90.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,700.0	1,200.0	2,500.0	32.4
210604	Урсгал засвар	39,538.6	38,038.6	1,500.0	96.2
2107	Томилолт, зочны зардал	6,180.0	6,180.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	6,180.0	6,180.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,157.1	48,349.7	2,807.4	94.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,058.5	46,251.3	2,807.2	94.3
210803	Даатгалын үйлчилгээ	124.0	124.0	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157.0	157.0	0.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	42.9	42.8	0.1	99.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	999.8	999.8	-	100.0
210807	Газрын төлбөр	774.9	774.8	0.1	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,680.0	57,240.0	6,440.0	89.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,680.0	57,240.0	6,440.0	89.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	276,669.7	210,639.7	66,030.0	76.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	225,557.8	159,527.8	66,030.0	70.7
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	225,557.8	159,527.8	66,030.0	70.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,111.9	51,111.9	-	100.0

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	695.7	695.7	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,710.1	21,710.1	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,706.1	26,706.1	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000.0	2,000.0	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	185,242.8	167,653.0	17,589.8	90.5
223001	Бусад хөрөнгө	185,242.8	167,653.0	17,589.8	90.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	206,000.0	116,000.0	90,000.0	56.3
230001	Эргэж төлөгдөх зээл	206,000.0	116,000.0	90,000.0	56.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,484,257.7	1,281,327.4	202,930.3	86.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	193,225.8	193,225.8	0.0	100.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	193,225.8	193,225.8	0.0	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	861,092.5	1,059,831.0	(198,738.5)	123.1
320001	Орон нутгийн төсвөөс	861,092.5	1,059,831.0	(198,738.5)	123.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	429,939.4	28,270.6	401,668.8	6.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	88,795.4	18,602.1	70,193.3	20.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000.0	9,668.6	(3,668.6)	161.1
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	335,144.0	-	335,144.0	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	140,889.1	(140,889.1)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	132,001.6	(132,001.6)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,209.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,209.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,709.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,709.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,709.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,209.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,209.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,859.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	350.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Цагаан-Үүр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл

авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх” зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тус сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 87.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд орон нутгийн ерөнхий орлого болон 5 төсөвт байгууллага, 2 орон нутгийн сан, 1 орон нутгийн өмчит ХХК нийт 9 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Үүнээс Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль мөн Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу эрүүл мэндийн төв болон Соёлын төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Засаг даргын 2022 оны А/80 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан байна.

Дотоод хяналтын нэгж нь 2022 онд 3 ажил хийхээр төлөвлөж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх болон төсвийн байгууллагуудын албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт хийхээр төлөвлөсөн боловч хяналтыг хэрэгжүүлсэн тухай болон хяналтаар илэрсэн зөрчлийн тухай тайлан мэдээлэл байхгүй байна. Мөн тус сумын Засаг даргын Тамгын газарт 1.5 сая төгрөгийн даргын гарын үсэг, тамгагүй гүйлгээ хийгдсэн зөрчил илэрсэн нь төрийн сангийн дотоод хяналт үр нөлөө багатай байгааг харуулж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө бага байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлээгүй байсныг аудитын явцад бэлтгүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн болгогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,315.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	423.0	1,237.9	814.9
Авлага	209.9	77.6	(132.3)
Бараа материал	832.3	507.2	(325.1)
Урт хугацаат зээл		87.0	87.0
Үндсэн хөрөнгө	2,546.3	783.8	(1,762.5)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,011.5	2,696.0	(1,315.5)
Богино хугацаат өр төлбөр	8.1	7.6	(0.5)
Засгийн газрын хувь оролцоо	4,003.4	2,688.4	(1,315.0)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,011.5	2,696.0	(1,315.5)

Эх сурвалж: Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн байдлын тайлан

Тайлант онд мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр, үндсэн хөрөнгө, бараа материал дансанд дараах хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 814.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд орон нутгийн орлого давж биелсэнтэй холбоотой байна.
2. Авлага дансны үлдэгдэл 132.3 сая төгрөгөөр буурахад хоршоо хөгжүүлэх сангийн авлага 48.8 сая төгрөгөөр буурсан болон эрүүл мэндийн төвийн авлагын эхний үлдэгдэл 105.8 сая төгрөг улсын төсөвт шилжсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 77.6 сая төгрөг байгаа ба үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 5 иргэнтэй холбоотой 32.2 сая төгрөг байна.

3. Бараа материалын дансны үлдэгдэл буурахад төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан ерөнхий боловсролын сургууль, эрүүл мэндийн төв, хүүхдийн цэцэрлэг, соёлын төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэнээр нийт 543.4 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн нь нөлөөлсөн байна. **Үүнд:** Ерөнхий боловсролын сургууль 297.8 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 113.7 сая төгрөг, эрүүл мэндийн төв 111.3 сая төгрөг, соёлын төв 20.6 сая төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлсэн байна.
4. Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангаас 116.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна.
5. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь Ерөнхий боловсролын сургууль 575.5 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 599.7 сая төгрөг, эрүүл мэндийн төв 302.9 сая төгрөг, соёлын төв 292.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт тус тус шилжүүлсэнтэй холбоотой байна.
6. Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 0.5 сая төгрөгөөр буурахад хүүхдийн цэцэрлэгийн 0.3 сая төгрөг, ерөнхий боловсролын сургуулийн 0.2 сая төгрөгийн өр улсын төсөвт шилжсэнтэй холбоотой байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт 2,298.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 1,268.4 сая төгрөгөөр буюу 35.6 хувиар буурсан байна.

Хүснэгт №2 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	240.7	1,259.8	1,019.1	523.3
Татварын бус орлого	527.2	243.7	(283.6)	46.2
Тусламж санхүүжилтийн орлого	2,798.4	755.2	(2,043.2)	26.9

Нийт дүн 3,566.4 2,258.8 (1,307.6) 63.3
 Эх сурвалж: Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан байгууллагууд улсын төсөвт шилжсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,153.8 сая төгрөгийн 17 орлогын давхардсан гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,153.8 сая төгрөгийн 17 орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 4,543.5 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №3: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөг/	
			Өсөлт бууралт	Хувь
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,996.4	997.8	1,998.6	33.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,777.5	363.2	1,414.3	20.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	233.7	46.5	187.2	19.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	141.7	186.4	(44.6)	131.5
Хангамж, бараа материалын зардал	101.0	46.9	54.0	46.5
Нормативд зардал	336.2	-	336.2	-
Эд хогшил, урсгал засварын зардал	29.0	35.2	(6.2)	121.5
Томилолт, зочны зардал	6.9	6.2	0.7	89.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	131.5	157.0	(25.4)	119.3
Бараа үйлчилгээний бусад зардал	238.8	156.3	82.5	65.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74.1	66.1	6.7	91.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	100.7	2,404.6	(2,303.9)	2,389.0
НИЙТ ДҮН	3,171.1	3,470.5	299.4	109.4

Эх сурвалж: Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт зардлын дүн өмнөх оноос 299.4 сая төгрөгөөр өссөн нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан 4 байгууллага улсын төсөвт шилжиж хаалтын тайлан хийсэнтэй холбоотойгоор үйл ажиллагааны бус зардлын дүн 2,303.9 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагааны зардал 1,998.6 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,153.8 сая төгрөгийн 17 зарлагын давхардсан гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,153.8 сая төгрөгийн 17 зарлагын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Цагаан-үүр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж орон нутгаас санхүүжүүлэх Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн байгууллагуудын тогтмол зардлыг тусгаж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Цагаан-Үүр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 06 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 1,615.1 сая төгрөгийн төсөв баталснаас 971.5 сая төгрөгийг урсгал зардалд, 435.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, Эргэж төлөгдөх зээлийн зардалд 207.7 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 639.7 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 230.6 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 308.3 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, давсан орлого дансны үлдэгдлээс 341.7 сая төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 94.8 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Цагаан-Үүр сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолоор төсөвт 130.9 сая төгрөгийн хасах тодотгол хийж төсвийг 1,484.3 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 28.3 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 1,093.4 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангаас 193.2 сая төгрөгийг нийт 1,314.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Цагаан-Үүр сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 02 дугаар тогтоолд зааснаар Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 308.3 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 1,264.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 410.2 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №4. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	125.0	158.1	33.1	126.5
Үйл ажиллагааны орлого	9.0	4.8	(4.2)	53.5
Хөрөнгийн орлого	20.0	18.3	(1.7)	91.5
Хөрөнгө борлуулсны орлого	0.1	1.2	1.1	1,030.7
Шууд бус орлого	-	2.4	2.4	
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(25.9)	(15.4)	10.5	59.6
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	8.6	2.6	(6.0)	30.0
Бууны албан татвар	3.2	2.6	(0.7)	79.4
Малд ногдуулах албан татвар	9.8	8.8	(1.0)	89.6
Улсын тэмдэгтийн хураамж	4.5	54.3	49.8	1,206.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.5	0.6	(0.9)	40.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4.3	3.5	(0.8)	80.7
Газрын төлбөр	14.5	7.0	(7.5)	48.1
Дуудлага худалдаа	-	0.8	0.8	
Ойн нөөц ашигласны төлбөр	121.6	968.8	847.2	796.6
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	5.6	40.1	34.5	711.6
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.4	0.2	(0.1)	64.3
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1.0	1.1	0.1	108.7
Торгуулийн орлого	5.0	4.8	(0.2)	95.5
ТӨСВИЙН ОРЛОГО	308.3	1,264.6	956.3	410.2

Эх сурвалж: Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Цагаан-Үүр сумын орон нутгийн орлого 956.3 сая төгрөгөөр давж биелэхэд иргэдийн цалин хөлс өссөнөөс цалин хөлс, хөдөлмөр эрхлэлтийн орлого 33.1 сая төгрөгөөр, самрын хураамжаас авсан гарал үүслийн зөвшөөрлийн орлого нэмэгдсэнээс улсын тэмдэгтийн хураамж 49.8 сая төгрөгөөр, байгалийн дагалдах баялаг самрын орлого нэмэгдсэнээс ойн нөөц ашигласны төлбөр 847.2 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 34.5 сая төгрөгөөр давж биелсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл үйл ажиллагааны орлого 4.2 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 1.7 сая төгрөгөөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 6.0 сая төгрөгөөр, бууны албан татвар 0.7 сая төгрөгөөр, малд ногдуулах албан татвар 1.0 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.8 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.9 сая төгрөгөөр, газрын төлбөр 7.5 сая төгрөгөөр, ус рашаан ашигласны төлбөр 0.1 сая төгрөг, торгуулийн орлого 0.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 12,300.1 сая төгрөгөөр төлөвлөж 9,609.4 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 2,690.7 сая төгрөг буюу 21.8 хувиар тасалсан байна.

Хүснэгт №5: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ААНОАТ /40 хувь/	2.4	-	(2.4)

2	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	8.5	8.3	(0.2)
3	Зам ашигласны төлбөр	1.4	1.3	(0.1)
	Нийт дүн	12.3	9.6	(2.7)

Эх сурвалж: Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл ААНОАТ-ийн орлогыг 2.4 сая төгрөгөөр, авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татварын 0.2 сая төгрөгөөр, зам ашигласны төлбөрийг 0.1 сая төгрөгөөр тус тус тасалжээ.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 7.9 сая төгрөгөөр төлөвлөж 7.9 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж бүрэн биелүүлж ажилласан байна.

Хүснэгт №6: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	2.5	3.7	1.2
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	2.2	3	0.8
3	Агаарын бохирдлын төлбөр /авто/	0.7	1.2	0.5
4	Агаарын бохирдлын төлбөр /эх үүсвэр/	2.5	-	-2.5
	Нийт дүн	7.9	7.9	0

Эх сурвалж: Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл агаарын бохирдлын төлбөрийн орлогыг 2.5 сая төгрөгөөр тасалсан байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 840.8 сая төгрөгөөр төлөвлөж, 774.3 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 92.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 94.8 сая төгрөгийг орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 28.3 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 1,484.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 867.4 сая төгрөгийг урсгал зардалд, 410.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 206.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 826.5 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 327.2 сая төгрөгийг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд 116.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,269.7 сая төгрөг буюу 85.5 хувьтай байна.

Хүснэгт №6 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/Хэмнэлт	Хувь
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,484.3	1,269.7	214.6	85.5
2 i	Урсгал зардал	1,093.0	986.0	107.0	90.2
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	816.3	775.4	41.0	95.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	387.5	363.5	24.0	93.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48.6	46.2	2.4	95.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	176.9	176.9	0.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	36.1	34.8	1.3	96.4
2105	Нормативд зардал	3.0	3.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43.2	39.2	4.0	90.7
2107	Томилолт, зочны зардал	6.2	6.2	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51.2	48.3	2.8	94.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63.7	57.2	6.4	89.9
213	Урсгал шилжүүлэг	276.7	210.6	66.0	76.1

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	225.6	159.5	66.0	70.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	51.1	51.1	-	100.0
22	Хөрөнгийн зардал	185.2	167.7	17.6	90.5
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	206.0	116.0	90.0	56.3

Эх сурвалж: Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Батлагдсан төсвөөс 214.6 сая төгрөгийг зарцуулаагүй нь хоршоо хөгжүүлэх сангаас олгохоор төлөвлөсөн 90.0 сая төгрөгийн зээлийг олгоогүй, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан 6 төсөл арга хэмжээ тайлант онд хэрэгжээгүйгээс 66.0 сая төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд нь дээд шатны төсвийн захирагчаас 8.9 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 0.3 сая төгрөг нийт 9.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 8.7 сая төгрөг, тэтгэмж урамшууллын зардалд 0.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орлогын биелэлт, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой болон шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням аудитын менежер Б.Төгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/33 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 61.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 49.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан байгууллагууд улсын төсөвт шилжсэнтэй холбоотойгоор материаллаг байдлын түвшнийг тайлант оны үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын дүн 1,103.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 21.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 17.0 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой гарсан 121.0 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, дараа жилийн төсвийн төсөл болон худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй зэрэг зөрчил илэрсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байгаа тул зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цагаан-Үүр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 1 албан шаардлага, 4 зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллах тухай өгсөн нэг зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 7 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	0.0	1	0.0	100
Зөвлөмж	4	12.7	3	12.7	75.0
Нийт дүн	5	12.7	4	12.7	80.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын гүйцэтгэл дутуугаас тайлант онд санхүүжилтийг дутуу олгож хөрөнгийг орлого аваагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн ерөнхий орлого болон төсвийн шууд захирагчийн 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Үүнд:

№	Байгууллагын нэр	Аудитын дүгнэлт
1	Засаг даргын Тамгын газар	Өөрчлөлтгүй дүгнэлт
2	Ерөнхий боловсролын сургууль	Өөрчлөлтгүй дүгнэлт
3	Хүүхдийн цэцэрлэг	Өөрчлөлтгүй дүгнэлт
4	Эрүүл мэндийн төв	Өөрчлөлтгүй дүгнэлт
5	Нарс шинэсэн төгөл ОНӨААТҮГ	Түүвэрт хамрагдсан
6	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Түүвэрт хамрагдсан
7	Соёлын төв	Түүвэрт хамрагдсан
8	Сум хөгжүүлэх сан	Түүвэрт хамрагдсан
9	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан

Тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эрүүл мэндийн төв болон Соёлын төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэн тул хаалтын тайлан гаргаж нэгтгэсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 88.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 45.8 сая төгрөгийн 1 алдааг залруулж 3.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 36.6 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 2.1 сая төгрөгийн 3 зөвлөмжийг өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 4,741.8 сая төгрөгийн алдааг илрүүлж аудитын хугацаанд бүрэн зааруулсан. Үүнд:

- Улсын төсөвт шилжсэн харьяа байгууллагуудын хаалтын тайланг нэгтгэхдээ шилжүүлсэн 2,313.4 сая төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийн тайлант үеийн зардлаар бүртгээгүй байна.
- Улсын төсөвт шилжсэн харьяа байгууллагуудын хаалтын тайланг нэгтгэхдээ өмчийн өөрлөлтийн тайланд 2,313.4 сая төгрөгийг хуримтлагдсан үр дүн дансыг зөрүүтэй нэгтгэсэн.
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэхдээ мөр мөрөөр нэгтгэх горимыг баримтлаагүй 38.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 76.0 сая төгрөгийн хоорондын тооцооны бичилтийг хийгээгүй байна.

Аудитаар 60.6 сая төгрөгийн зөрчил илэрч 1 албан шаардлага, 4 зөвлөмжийг хүргүүлж байна.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

1. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой

1.1. Илрүүлэлт:

Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгөгдсөн дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, илэрсэн зөрчилд хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцож ажиллах тухай зөвлөмжийг тайлант онд хэрэгжүүлж ажиллаагүй, Засаг даргын дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгж нь 2022 онд дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж тайлагнаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 3.7.1 "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах, 3.7.3 илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах; 3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх; гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2 Өгсөн албан шаардлага

Өмнөх оны аудитын зөвлөмжийг биелэлтийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн ирүүлээгүй бөгөөд аудитын хугацаанд нөхөж ирүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.4."хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан", 54.5.5."нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж байх.

2. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 953.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч нэр төрлөөр нь авч үзвэл 28.4 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

3. Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн 5 иргэнтэй холбоотой 32.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хоцорсон зээл, хүүгийн үлдэгдлийг төвлөрүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

4.1. Илрүүлэлт:

Шилэн дансны тухай цахим хуудсанд өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой гарсан 121.0 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, дараа жилийн төсвийн төсөл болон худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй зэрэг зөрчил илэрсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цагаан-Үүр сумын ТТЗ	3	4,741.6	1	2,313.4	2	2,426.4	3	4,741.6				
Дүн	3	4,741.8	1	2,313.4	2	2,428.4	3	4,741.8	0	0	0	0
Харьяа байгууллагуудын алдаа												
Цагаан-Үүр ЗДТГ	1	45.8			1	45.8	1	45.8				
ДҮН	1	45.8	0	-	1	45.8	1	45.8	0	0	0	0
нийт дүн	4	4,787.6	1	2,313.4	3	2,474.2	4	4,787.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цагаан-Үүр ТТЗ	4	60.6			1	0	3	60.6				
Дүн	4	60.6			1	0	3	60.6				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Цагаан-Үүр сумын ЗДТГ	4	40.8	1	3.6	1	36.6	2	0.6				
Дүн	4	40.8	1	3.6	1	36.6	2	0.6				
Нийт дүн	8	101.4	1	3.6	2	36.6	5	61.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
ТТЗ	1	0						1	0
Харьяа байгууллагуудын зөрчил									
Цагаан-Үүр ЗДТГ	1	1.6						1	1.6
Дүн	2	1.6						2	1.6

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
БАТАЛГААЖУУЛСАН:
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 24 өдөр

№ 64/2023-70648/ХӨА-2023/139
/ХӨА-СГА-ТТЗ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Цагаан-Үүр сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгж нь 2022 онд дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж тайлагнаагүй.
- Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгөгдсөн дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, илэрсэн зөрчилд хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцож ажиллах тухай зөвлөмжийг тайлант онд хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 3.7.1 “зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах, 3.7.3 илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах; 3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх; гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй”, гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх оны аудитын зөвлөмжийг биелүүлээгүй, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, төсвийн сахилга батыг сайжруулж ажиллах.
2. Албан шаардлагын биелэлтийг биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Цагаан-үүр сумын Засаг дарга А.Батмөнх, санхүүгийн албаны дарга О.Лхампүрэв нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО



¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043